

## Шашны итгэл үнэмшлийг тодруулах туршилт, тоглоомын судалгаа

Ц.Мөнхзаяа

ШУА-ын Түүх, угсаатан зүйн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний туслах  
ажилтан

[munkzayaa@gmail.com](mailto:munkzayaa@gmail.com)

### Хураангуй

Антропологийн судалгаанд нийгмийн зохион байгуулалт, хүмүүс хоорондын харилцааг ярилцлага, оролцон ажиглах арга зүйгээр судлахаас гадна нийгмийн сүлжээний торлог (social network analysis) болон туршилтын (experiment) арга зүйг ашиглаж илүү нарийвчлалтай үр дүнг гаргахад нөлөөтэй байгаа билээ. Тус өгүүлэлд туршилт тоглоомын арга зүйд тулгуурлан бэлчээрийн мал аж ахуй, нийгэм соёлын өөрчлөлт дунд Дорнод болон Увс аймаг дах шашны итгэл үнэмшил сэдвээр явуулсан судалгааны үр дүнг ашиглав. Бидний судалгаандаа хэрэглэсэн арга нь туршилт, тоглоомын онолын (experiment, game theory) арга зүй бөгөөд энэхүү арга нь хүний дадал, зан үйлийг баримтжуулан авч, тоон мэдээлэл бүрдүүлж, чанарын мэдээллээр тайлбарласнаар судалгааны бодитой, найдвартай, үнэмшилтэй байдлыг нэмэгдүүлдэг ач холбогдолтой юм. Тиймээс шашин шүтлэг, итгэл үнэмшил нь хүмүүс болон бүлгүүдийн харилцаанд хэрхэн нөлөөлж байгааг илрүүлэхэд тус арга зүйг ашиглах нь үр дүнтэй байв. Мөн байгалийн болон нийгмийн нөөц баялаг тухайлбал ижилсэл-ондоошил, үнэт зүйлс (virtues), бэлчээр ус зэргийг хэрхэн хамтран ашиглаж, хуваалцаж, харилцан тусалж (reciprocity) байгааг бүлгийн болон хувь хүний хүрээнд судлахад нийцэж байснаараа онцлог билээ.

**Түлхүүр үг:** судалгааны арга зүй, оролцогч, мөнгө хуваарилалт

### Судлагдсан байдал

Эдийн засгийн туршилт, тоглоом (economic experimental games) нь хүмүүсийн хамтын ажиллагаа, шударга ёс, өгөөмөр зан, альтруизмыг (бусдын төлөө хийж буй үйлдэл) ойлгох арга хэрэгсэл болж байна. Ашигтай сонголтын онолыг (rational choice theory) баримтлагчид хувь хүмүүсийг ашиг хөөгч, хувиа бодсон, өөртөө хамгийн ашигтай сонголтыг хийдэг агент гэж үздэг. Энэхүү онолын дагуу хүмүүс бусадтай итгэлцэлгүй нөхцөлд заавал өөрийгөө хамгаалж, хувийн ашиг сонирхлоо нэгдүгээрт тавина гэж таамагладаг. Жишээлбэл, шоронгийн хоригдлын дилемма (prisoner's dilemma, PD) хэмээх туршилтын тоглоомд оролцогчид бие биедээ итгэх үндэсгүй тул өөрийн ялыг багасгахын тулд хамтрагчаа “матах”, өөрөөр хэлбэл хамтын ажиллагаанаас татгалзах сонголтыг хийнэ гэж үздэг. Үүнтэй адилаар мөнгө хуваарилах тоглоомд оролцогч (dictators) бүх мөнгийг

өөртөө үлдээж, бусад оролцогчдод (trustors) юу ч өгөхгүй гэж таамагладаг. Гэвч бодит амьдрал дээр онолын таамаглал зөрж, хүмүүс бие биедээ өгөөмөр, харилцан тусалж, хамтын ажиллагаатай байдаг нь тогтоогдсон (Camerer 2003).

Энэ нь антропологийн уламжлалт маргаан дагуулж ирсэн формалистууд (formalists) ба субстантивистуудын (substantivists) хоорондын зөрчилтэй шууд холбоотой юм. Формалист үзэл нь эдийн засгийн шинэ сонгодог онолд тулгуурлаж, рациональ сонголт бүх нийтийн шинжтэй гэж үздэг (Firth 1967; Giddens, 1979). Харин субстантивистууд Карл Поланий онолд тулгуурлан эдийн засгийг нийгэм, соёлын харилцаанаас салшгүй төдийгүй эдийн засгийн үйл ажиллагаа нь төрөл садны холбоо, ёс суртахууны хэм хэмжээ, зан заншил, итгэл үнэмшил зэрэгт “суурилагдсан” (embedded) хэмээн маргадаг ажээ (Sahlins, 1972). Цаашлаад Мүүк (1986), Тёрнер болон Браш (1987) эдийн засгийн харилцаан дахь хүмүүсийн дадал нь рациональ агуулгаас гадна бэлгэдлийн шинжтэй гэж үзсэн.

Гидденсийн (1979) бүтцийн хоёрдмол шинж (duality of structure) хэмээх ойлголт эдгээр маргааныг нэгтгэн тайлбарлах боломж олгодог. Түүний үзлээр нийгмийн бүтэц нь хувь хүмүүсийн үйлдлийг чиглүүлж, хязгаарлаж байдаг боловч хүмүүс өөрсдийн өдөр тутмын үйлдлээр дамжуулан тэрхүү бүтцийг байнга дахин бий болгож байдаг. Иймээс нийгэм, соёл нь хүнийг нэг талдаа удирдан чиглүүлдэг боловч нөгөө талдаа хувь хүмүүс өөрсдөө тухайн нийгэм, соёлыг тасралтгүй бүтээж байдаг байна.

Туршилтын тоглоомууд эдгээр үзэл баримтлалыг хооронд нь холбож өгдөг. Тоглоомын онол нь рациональ сонголт хийх үйл явцыг судлах төдийгүй, нийгэм соёлын үнэт зүйлс, хэм хэмжээ, ураг төрлийн харилцаа, шашин шүтлэг зэрэг нь шийдвэр гаргахад хэрхэн нөлөөлж байгааг судлах болсон юм. Нөөц хуваарилах, хуваах тухайд диктаторын тоглоом (dictator game, DG), итгэлцлийн тоглоом (trust game, TG), хоригдлын дилемма (prisoner's dilemma, PD) зэргийг ашиглаж болох ба бүгд өөрийн гэсэн хэвшиж тогтсон арга зүй, дүрэмтэй боловч улс орон, соёл болгонд харилцан адилгүй үр дүн гардаг.

Туршилт тоглоомыг ашигласан судалгаануудаас дурдвал, эдийн засгийн антропологийн судалгаатай хослуулан ашигласан хамгийн нөлөө бүхий ажлуудын нэг нь Хенрих нарын (2005, 2010) хэрэгжүүлсэн “15 соёл” (Fifteen Small-Scale Societies Project) судалгааны төсөл юм. Үүндээ хамтын шийдвэрийн тоглоом (ultimatum game) буюу нэг нь хувааж нөгөөх нь зөвшөөрөх эсвэл татгалзах тухай, диктаторын тоглоом (DG) буюу нэг тал нь дангаараа мөнгө хуваах тухай, нийтийн ашиг сонирхлын тоглоом (public goods game, PGG) буюу дундын сан үүсгэж, өөртөө, эсвэл нийтэд хуваарилах туршилтын тоглоом ашиглан судалгаа явуулсан. Эдгээр тоглоомыг анчид, тариачид, малчдын дунд явуулж зах зээлийн харилцаа илүү хөгжсөн, мөн шашны итгэл

үнэмшил хүчтэй нийгэмд хүмүүс илүү шударга, өгөөмөр зан гаргах хандлагатай гэсэн дүгнэлтэд хүрчээ.

Үүнтэй төстэй Гурвены (2004) Боливийн Цимане (Tsimane) хүмүүсийн дунд хамтын шийдвэрийн тоглоом (UG) ашигласан судалгаагаар хүмүүс хийсвэр шударга ёсны зарчмыг баримтлахаас илүүтэй нутгийн уламжлалт хуваалцах зан үйл давамгайлж байгаа нь илэрчээ. Кронк (2007) Масайчуудын (Maasai) дунд диктаторын тоглоомын туршилт явуулж, хүмүүс бусдад мөнгө хуваарилахдаа тэгш хуваарилалт хийхээс илүүтэйгээр тухайн хүний хэрэгцээ, нөхцөл байдлыг харгалзан үздэг зүй тогтол байгааг илрүүлжээ. Мөн Марлоу (2004), Хилл нар (2014) Хадза (Hadza) анчид, түүвэрлэгчдийн дунд хийсэн судалгаагаар хамтын ажиллагаа, өглөгч зан нь хувь хүмүүсийн хоорондын ойр дотно харилцаатай шууд уялддаг болохыг тогтоосон байна. Өөрөөр хэлбэл хүмүүс өөрт ойр, итгэлцэлтэй хүмүүстээ илүү өгөөмөр ханддаг бөгөөд үүний үр дүнд өгөөмөр хүмүүс хоорондоо илүү нягт сүлжээ үүсгэдэг бол хувиа бодох хандлагатай хүмүүс мөн адил хоорондоо холбогддог зүй тогтол ажиглагдсан байна. Герки (2013) Оросын загасчдын дунд тоглоом, ярилцлага хослуулж судалсны үр дүнд хүмүүс хувиа бодохын оронд ураг төрлийнхний хүлээлтэд тааруулах, экологийн орчинд тохируулан шийдвэр гаргаж, хамтран ажилладаг гэж үзсэн. Эдгээр нь эдийн засгийн рациональ байдал нь цаг үргэлж соёлоос хамаардаг гэдгийг харуулсан юм.

### **Бурхан, тоглоом ба нийгэм-экологийн орчин**

Харин бидний оролцсон судалгаа нь Пүрзийский нарын (2016) найман улсад явуулсан тоглоомын туршилт судалгаа бөгөөд “бурхны шийтгэл” болон “бурхан биднийг үргэлж харж хянаж байдаг” гэх итгэл үнэмшил нь өөр өөр газар байгаа ижил шашин шүтлэгтэй хүмүүст ижил байгааг харуулсан байна. Бендиксен, Лайтнер, Пүрзийский нар (2023) 15 улсад үргэлжлүүлэн судалгаа явуулж, лус савдаг зэрэг орон нутгийн итгэл үнэмшил нь хүмүүсийн ёс суртахуунд ижил нөлөөлдөг эсэхийг судалж байгаа юм. “Бурхан, тоглоом ба нийгэм-экологийн орчин” (Gods, Games, and the Socioecological Landscape, GGSL) төсөл диктаторын тоглоом (DG), санамсаргүй хуваарилалтын тоглоом (Random Allocation Games) зэрэг туршилтын арга ашиглаж, орон нутгийн итгэл үнэмшил нь хувиа бодох байдлыг багасгадаг эсэхийг судалж байгаа юм. Ингэхдээ Монгол улсын Дорнод, Увс гэсэн 2 аймагт хээрийн судалгаа явуулсан билээ.

Энэ чиглэлийн судалгаанд монголын жишээ маш чухал байр суурь эзэлж байна. Конте (2022) “Тал нутгийн өгөөмөр сэтгэл” (Steppe Generosity) нэртэй судалгаандаа Завхан аймгийн малчдын дунд туршилтын тоглоомын арга хэрэглэсэн. Тэрээр “хэнд өгч байгаагаас шалтгаалан шийдвэр гаргах” буюу хүлээн авагчийн онцлогоос хамаарсан шийдвэрийн дүрэм (Recipient Identity Conditioned Heuristic, RICH) хэмээх аргыг ашиглаж, хүмүүс мөнгө хуваахдаа хүлээн авах

хүний төрөл садан, нэр хүнд, бодит хэрэгцээг хэрхэн харгалзан үздэгийг судалжээ.

Тоглоомын үр дүнд оролцогчид эдгээр хүчин зүйлийг харгалзан үзээд, өөрсдөд оногдсон нийт мөнгөнийхөө ойролцоогоор 80 хувийг бусдад өгөх шийдвэр гаргасан байна. Энэ нь ураг төрлөө дэмжиж өөрийн генийг үргэлжлүүлэх (inclusive fitness theory) (Hamilton, 1964) тухай онол, илүү их өртөг, цаг хүч зарцуулж итгэлтэй хүн гэдгээ батлах (costly signaling theory) (Bliche Bird et al., 2001) онол, хэрэгцээтэй үед нь тусалж өөрт ирэх ирээдүйн эрсдэлийг давах (need-based transfers) (Cronk & Aktipis, 2018) тухай онол, мөн монголын бие биедээ туслан амьдардаг хот айлын системийн тухай этнографийн судалгаатай (Bold, 1996; Humphrey & Sneath, 1999) нийцэж байна.

Энэ судалгаа нь тоглоом, туршилтаар дамжуулж жижиг соёлын бүлгийн дунд уламжлалт шашин ба хамтын ажиллагааны харилцааг судалсан юм. Үүнд шашны итгэл үнэмшил, ялангуяа бурхны шийтгэлтэй холбоотой ойлголт нь хүмүүсийг дүрэм журам сахиж, бусдад өгөөмөр хандахад хэрхэн нөлөөлдөг талаар туршилтын тоглоом ашигласан байна. Ийнхүү туршилт, тоон аргыг ашигласнаар шашин нь орон нутгийн хамтын ажиллагааны асуудлыг шийдвэрлэхэд ямар үүрэг гүйцэтгэдгийг харьцуулахад дөхөм болсон байна. Өөрөөр хэлбэл шашин шүтлэг нь зөвхөн хувь хүнд чиглэсэн итгэл биш, харин бүлгийн дотоод хамтын ажиллагааг дэмжих хөшүүрэг болж, олон янз хэлбэрээр оршиж, хадгалагдаж байгааг тодруулах болсон юм. Дараах хэсгүүдэд судалгааны багийн нэгэн хэсэг болж ажилласан тухай, туршилт тоглоомын арга зүйг ашигласан талаар хуваалцах болно.

### **Хээрийн судалгаа, бэлтгэл ажил**

8 гишүүнтэй судалгааны баг маань Улаанбаатар хотоос хөдлөхөөс өмнө 5 хоногийн сургалтад хамрагдаж, судалгааны зорилго, үндэслэл, ач холбогдлын талаар танилцах шаардлага бий болсон. Судалгааны төслийн удирдагч, Дани улсын Аархуусын их сургуулийн Шашин судлалын тэнхимийн дэд профессор Бэнжамин Грант Пүрзийский хүрэлцэн ирж судалгааг хэрхэн үр дүнтэй хэрэгжүүлэх талаар хоёр өдрийн сургалт зохион байгуулсан юм. Үүний дараа хээрийн судалгааны удирдагч И.Бямбабаатар багшийн удирдлага дор 3 өдрийн турш МУИС дээр цугларч, судалгааны асуулгыг нарийвчлан ойлгож, нэг нэгнээсээ асууж, давтаж үзсэн юм. Судалгааны асуулгыг монгол хэл рүү орчуулах явцад зарим өгүүлбэрийн утга монгол хүний сэтгэхүйд нийцэхгүй, соёлын ялгаатай агуулга цөөнгүй байсан тул тухайн хэсгийг өөрийн хэлний онцлогт тохируулан ойлгомжтой байдлаар хувиргаж, зассан. Мөн энэхүү тоглоомын судалгаанаас гадна манай багийн гишүүн, МУБИС-ийн ардын дуу судлалын магистрын оюутан нь буриад угсаатны бүлгийн ардын дууг судалж, баримтжуулах нэмэлт судалгааг гүйцэтгэх үүрэгтэй байсан.

Мөн аливаа орон нутагт судалгааг амжилттай хэрэгжүүлэхэд орон нутгийн хөтөч чухал үүрэг гүйцэтгэдэг. Хээрийн судалгаанд гарахаас өмнөх нэгэн чухал алхам бол тухайн орон нутгийг сайн мэддэг, итгэлтэй хөтчийг сонгох явдал юм. Учир нь хөтөгчгүйгээр орон нутгийн хүмүүст өөрсдийгөө болон судалгаагаа ойлгуулж, тайлбарлах нь хүнд даваа болдог. Харин тухайн нутгийн, олон хүн таньдаг хүнийг хөтөч болгосноор нутгийнхан судалгааг хор хөнөөлгүй, итгэж болохуйц хэмээн үзэхэд нөлөөлж, хамрагдах оролцоо нь нэмэгддэг.

Ийнхүү 8 хүний гишүүнтэй судалгааны баг маань Баяндун суманд 14 хоногийг өнгөрөөсөн юм. Багийн 6 гишүүн хоёр хоёроороо баг болж 3 баг тоглоомын туршилтын судалгааг хэрэгжүүлж, 80 хүнээс туршилт тоглоомыг тоглуулах зорилготой байсан. Харин дуу судлаач болон хөтөч хоёр маань нэг баг болж сумын ахмад настнуудтай уулзаж, буриад ардын дуу дуулж байгааг мэргэжлийн багаж хэрэгслээр бичлэг, дүрс хийх үүрэгтэй байв. Эдгээр цуглуулсан дүрс бичлэгээ баримтат кино болгож, нэг жилийн дараа дахин энэ сумд ирэхдээ энэхүү бичлэгийг айлуудад үзүүлсэн төдийгүй соёлын өвийн хамгааллын төвд өгсөн. Энэхүү соёлын өвийн баримтжуулалт нь мартагдаж буй өв соёл, дуу хуур түүнийг сэргээх, хадгалах, хойч үедээ өвлүүлэх ач холбогдолтой.

Энэ судалгаанд туршилт тоглоомын арга зүйг ашиглахаас гадна гишүүн бүр хувийн судалгаагаа өргөжүүлэх боломж олдож тэр тухай ярилцлага хийж чанарын судалгааг ч мөн орхиогүй билээ. Сонирхуулан дурдахад, уул усны эздийн талаар, монголын нүүдлийн соёл иргэншлийн тулгамдаж буй асуудал, буриад ардын хүндлэх ёс, өмч болон газрын харилцааны зөрчил маргаан, монголчуудын сайн муугийн үнэлэмж, малчдын махны худалдаа зэрэг сэдвийг судалж зарим нь үүнийгээ бакалаврын дипломын ажил болгож, зарим нь богино хэмжээний нийтлэл болгосон юм.

## **Судалгаа хийсэн газар, орчин**

Энэхүү судалгааг Дорнод аймгийн Баяндун сумын Хайрхан, Наран, Түргэн, Яргай багийн хүн амын дунд явуулсан болно. Дорнод аймгийн төв Чойбалсан хот нь Улаанбаатар хотоос 665 км, харин Чойбалсан хотоос Баяндун сум хүртэл 176 км зайд оршдог. 2024 оны байдлаар Баяндун суманд нийт 282.4 мянган таван хошуу мал тоологдсон байна. Монгол улсад нийт 195 мянган малчин өрх бүртгэлтэй байдгаас 510 өрх нь Баяндун суманд хамаарах бөгөөд нийт 308,746 малчин байгаагаас 766 нь Баяндунгийн малчид юм. Хүн амын хувьд тус суманд нийт 3,189 хүн оршин сууж байна.<sup>1</sup>

Энэ сумын хүн амын дийлэнхийг буриад угсаатны бүлэг бүрдүүлдэг онцлогтой. Тэд бөө мөргөл, уул овооны тахилгыг ихэд чухалчлан авч үздэг бөгөөд Хайрхан, Угтам зэрэг уул овоог тахиж

---

<sup>1</sup> Үндэсний статистикийн хороо

шүтдэг уламжлалтай. Зарим хүмүүс ОХУ-д амьдарч буриад түмэнтэй холбоотой байдгаа дурдсан бөгөөд Оросын нутагт орших Алхай хэмээх уулыг шүтдэг тухайгаа онцлон ярьж байв.

Баяндун сумын айл өрхүүд бусад аймгийн сумын төвөөс харьцангуй онцгой байсан. Сумын төвд амьдарч байгаа айл бүр хашаандаа мод, жимс, олон төрлийн ногоо тарьсан байв. Мөн хөдөөгийн малчин айлууд ч монгол гэрээс гадна вагончикийг хамт авч явдаг.

Биднийг очих үеэр төрөөс санаачилсан “Шинэ хоршоо” хөтөлбөрт олон айлууд нэгдэж байсан ба тухайн хөтөлбөр эрчимтэй хэрэгжиж байлаа. 10 хүртэлх айлууд нийлж нэг хоршоо болоод 6%-ийн хүүтэй 50 сая төгрөгийн зээлийг айл бүр авч, тоног төхөөрөмж оруулж үйлдвэрлэл байгуулна хэмээн тайлбарлаж байв. Бидний зочилсон нэгэн айл хадлангаар дагнаж үйлдвэр байгуулах бол өөр нэгэн айл махны бизнес эхлүүлэхээр зэхэж байгаагаа хэлж байв. Харин үүнтэй зэрэгцэн нэгэн ахмад настан “50 саяын 25 сая нь айлын байшин, машин болоод дуусаж байна”<sup>2</sup> хэмээн шүүмжлэлтэй байр суурийг илэрхийлж байлаа.

Өнгөрсөн 2023-2024 оны өвөлжилт улсын хэмжээнд хүндэрч нийт нутаг дэвсгэрийн 70 орчим хувь нь зудад нэрвэгдсэн бөгөөд 2023 онд 4.9 сая мал өвс тэжээлгүй, шуурганд даарч бээрсний улмаас хорогдсон байна.<sup>3</sup> Харин Дорнод аймаг өвс ургамал өндөр ургадаг, тэр дундаа Баяндун сумын буриад түмэн хадлангаа сайн базаадаг уламжлалынхаа ачаар зудын хүндрэлийг амжилттай даван туулжээ.

Ийнхүү байгаль, экологийн хувьд харьцангуй таатай нөхцөлтэй нутаг учраас Баяндун суманд бусад аймаг сумаас малчид нүүж ирдэг хөдөлгөөнтэй сум хэмээн үзэж байна. Харин хаа сайгүй бэлчээрийн маргаан газар авсан энэ үед Баяндун сумынхан ч мөн өөр сумаас нүүж ирсэн малчдад болгоомжтой, хянуур хандах гэж хичээдэг гэв. Ихэнхдээ баруун аймгаас малчид нүүж ирдэг бөгөөд нутгийн малчин ийнхүү өгүүллээ:

“Сум сумын зааг дээр ирээд буучихдаг юм байна. Сэргэлэн, Баян-Уул, Баяндун 3 сумын зааг дээр ирж буугаад гэж хаанахын хүмүүс вэ гээд асуухаар манайх Баяндунгийнх гээд, Сэргэлэнгийн хүн асуувал манайх Баян-Уулынх гээд, Баян-Уулын хүн асуувал Сэргэлэнгийнх гэххээд байж байдаг”.<sup>4</sup>

Ингэж зөрүүлж хариулт өгснөөр нүүж ирсэн айлууд хөөгдөх аюулаас зугтдаг ажээ. Аймгийн төвөөс 170 км гаруй зайтай тул малчдын бүтээгдэхүүнийг зарж борлуулахад тусалдаг 2 ченж тогтмол ажилладаг. Сүүлд сумын төвийн урд хэсэгт бой буюу нядалгааны газрыг байгуулж малчдаас мал авдаг болсон байна. Нэг талаараа малчдын ажлыг хөнгөвчилж, цаг хэмнэж байгаа боловч нөгөө талаар

<sup>2</sup> Ярилцлага, Ө, 2024, 7-р сарын 18

<sup>3</sup> <https://www.cpr.mn/?p=913>

<sup>4</sup> Ярилцлага, Д, 2024 он, 7-р сарын 22

ченжүүд тэдний бүтээгдэхүүнийг маш хямд үнээр худалдаж авдагт малчид сэтгэл дундуур байлаа.

### **Мэдээллийн төрөл, цуглуулах үйл явц**

Энэхүү судалгааг өдөрт нэг баг 5-7 хүнээс авах боломжтой байсан. 1 хүнээс судалгаа авахад 1 цаг 30 минут зарцуулах бөгөөд үүнд хүн амын асуулга, тоглоом, шашны тухай асуулга гэсэн дарааллаар үргэлжилнэ. Хүмүүсийн овог нэрийг нууцалж хүн бүрийг BI001-BI0100 хүртэлх кодоор кодчилсон ба асуулга бүр дээр оролцогчийн нэрээр биш кодоор нь тэмдэглэсэн.

Судалгааны ерөнхий санаа нь шашин, итгэл үнэмшил болоод хүний шийдвэр гаргалт хэрхэн холбогдож, хоорондоо нөлөөлж байдгийг илрүүлэх зорилготой. Тоглоомд оролцогч нь сайн дураараа байх бөгөөд хүсэхгүй бол шууд татгалзаж болно. Тоглоомыг тоглох үед оролцогч ганцаараа үлдэх бөгөөд тоглоомын дүрмийг зөрчих эсэх нь шууд тэрхүү оролцогчоос хамаарч байсан. Үүгээрээ хүний зан байдлыг ч тандаж болох өргөн хүрээний ажиглалтын боломжийг бидэнд олгож байсан билээ. Тоглоом нь дотроо 4 үе шаттай, тоглоомын давуу тал нь урамшуулалтай байсан явдал юм. Тиймээс орон нутгийн хүмүүст маш амархан тархаж байв. Даалгаврыг гүйцэтгэж, хожсон мөнгө оролцогчид урамшуулал болон очих юм. Харин энэ мөнгө нь судлаачийн хувийн мөнгө биш бөгөөд МУИС судалгаанд зориулж гаргасан мөнгө юм. Энэхүү судалгаа нь Эрдэм шинжилгээний зорилготой бөгөөд хүмүүсийн нэрсийг бид судалгаандаа ашиглахгүй. Мөн аль нэг нам эвсэл, төсөл хөтөлбөр, байгууллагын судалгаа биш юм гэдгээ ойлгуулж, өөрсдийнхөө талаар мэдээлэл хүргэж итгэлцлийг бий болгосон юм.

Тоглоом эхлэхэд оролцогчийн урд Дорнод аймгийн Баяндун болон Ховд аймгийн Дуут сумыг төлөөлөх хоёр аягыг байрлуулна. Судлаач тоглоомыг эхлүүлэхийн өмнө энэ хоёр сум буриад зон олон давамгайлсан, ижил төрлийн шүтлэг бишрэлийн ижил төсөөтэй байдлыг оролцогчид тайлбарлах үүрэгтэй. Туршилтад 3 тал нь хар, 3 тал нь цагаан өнгөтэй нэг шоог ашиглана. Оролцогч тоглоом эхлэхээс өмнө шооны аль нэг өнгийг Баяндун сумтай, нөгөө өнгийг Дуут сумтай төсөөлөн бодно. Нийт 30 удаа шоог хаях ба шоо хаях бүрд буусан өнгөний дагуу нэг зоосыг аяганд хийнэ. Тухайлбал, Баяндун сумыг цагаанаар төсөөлсөн байж байгаад шоо хаяхад цагаан буувал зоосыг Баяндунгийн аяга руу хийх юм. Зоос бүрийг бид 1000 төгрөгөөр үнэлсэн. Энэ даалгаврыг ганцаараа гүйцэтгэх ба дууссаны дараа аягыг бид авч, зоосны тоогоор мөнгийг хуваарилж, санамсаргүй байдлаар Баяндун болон Дуут сумынханд тараах бөгөөд мөнгө авсан хүмүүс тэр хүний тухай мэдэхгүй.

Хоёрдох тоглоом нь аяганы нэр солигдож Дуут болон Өөртөө/Би болох юм. Мөн адил шоо орхиж хар цагааны аль нэгийг өөртөө болон Баяндун гэж төсөөлөх ба өөртөө гэсэн аяга руу орсон зоос

бүрийн тоогоор 1000 төгрөгийг тооцоолж тухайн хүнд өгөх юм. Үүний дараа энэ тоглоом амьдрал дээр болдог юуг санагдуулж байгаа, энэ судалгааг юу гэж бодож байна вэ гэсэн хоёр асуултыг асууж товч хариулт авна.



Зураг 1. Шоо орхиж аяганд зоос хуваарилах тоглоомын хэрэгслүүд<sup>5</sup>

Дараагийн тоглоом бол оролцогчид 2 хоёр дугтуй өгөх ба нэг нь Баяндун, нөгөө нь Дуутын хүнийх. Бид 10 ширхэг 1000 төгрөг буюу 10,000 төгрөгийг өгөхөд оролцогч хоёр дугтуйнд хуваарилж хийнэ. Ганцаараа үлдэж энэхүү даалгаврыг гүйцэтгэх бөгөөд хэн ч хэр их мөнгө хуваарилж байгааг мэдэхгүй. Бид мөнгийг оролцогчийн хуваарилсны дагуу санамсаргүй байдлаар хүмүүсийг сонгож өгнө. Сүүлийн тоглоом бол хуваарилах мөнгөний эзэд өөрчлөгдөж Дуут болон Өөртөө/Би болох юм. Өөртөө хуваарилсан мөнгийг оролцогчид өгөх бол үлдсэнийг санамсаргүй байдлаар Дуутад тараах юм. Ийнхүү бид бүх оролцогчдоосоо судалгаа авч дууссаны дараа тэдний Баяндунд хуваарилсан мөнгийг сумын төв болон сумаас зайдуу малчин өрх айлуудаар явж тараасан бол Дуут суманд хуваарилсан мөнгийг Дуут судалгааны багийнханд шилжүүлсэн юм.

Тоглоомын дараа 63 асуулга бүхий шашны тухай асуумжийг оролцогчтойгоо хамт бөглүүлсэн билээ. Энэ судалгаа нь гаднын олон оронд хэрэгжсэн учир зарим асуултууд нь ойлгомжгүй тул тайлбарлах ёстой билээ. Үүнд бурхны шашны талаар, уул усны эздийн талаар, гаднын шашин, цагдаагийн талаар асуудаг. Тухайн өдрийн цуглуулсан мэдээллээ орой нь буулгаж, шивэх шаардлагатай.


Ийнхүү жинхэнэ мөнгийг ашиглаж тоглоом тоглуулж, туршилт хийх нь энэхүү судалгаанаас хайж буй зүйлээ олох мэт үр дүнтэй

<sup>5</sup> Зургийг И.Бямбабаатарын (Ph.D) хувийн архиваас татаж авав.


байсан билээ. Учир нь хүн үргэлж хувийн эрх ашиг, сайн сайхны төлөө шийдвэр гаргадаг гэсэн хэвшмэл ойлголтыг унагах болсон юм. Хүмүүс дугтуйнд мөнгө хуваарилахдаа ихэвчлэн тэнцүү юм уу эсвэл өөртөө гэсэн дугтуйг хоосон үлдээж байв. Энэ нь хүмүүсийн шийдвэр үргэлж хувийн ашиг сонирхлоор хязгаарлагддаггүй харин хүмүүс хоорондын харилцаа, амьдралын туршлага, нийгмийн үнэ цэн хүний сонголтод нөлөөлдөг гэдгийг харууллаа. Үндсэн судалгааны багийнхан эдгээр өгөгдлүүдийг ашиглаж илүү сонирхолтой үр дүнг танилцуулна хэмээн найдаж байна. Энэхүү судалгаанд ашигласан диктаторын болон санамсаргүй хуваарилалтын тоглоомууд нь Хэнрих нарын (2005, 2010) олон соёлын харьцуулсан судалгаанд ашигласан загвартай ижил бөгөөд орон нутгийн соёлын нөлөөг илрүүлэх зорилготой.

### **Төлөөлөх чадвар, оролцогчдын хамрагдалт, санамсаргүй сонголт**

Бид судалгаа явуулахдаа Баяндун сумын хүн ам, тэдний үзэл хандлагыг аль болох өргөн хүрээтэй хамруулах зорилготой байсан тул нийт 82 тоглогчийг татан оролцуулсан. Судалгаанд оролцогчдыг сонгохдоо нас хүйс, амьжиргааны хэлбэр, ажил мэргэжил, амьдарч буй бүсийн ялгааг харгалзан үзсэн ба цуглуулсан мэдээлэл маань бодит байдлыг илэрхийлэх чадвартай байх нөхцөлийг бүрдүүлсэн юм. Ингэхдээ сумын захиргаатай хамтран судалгаанд оролцох боломжтой иргэдийн урьдчилсан жагсаалт гаргуулсан. Гэвч энэхүү жагсаалтыг шууд ашиглахаас илүү нутагтаа амьдарч байгаа 18-25 насны хүмүүсийг олоход л ашигласан билээ. Харин дунд, идэр, ахмад настнуудыг сонгохдоо сумын төвийн гудамжаар алхаж, дэлгүүр хоршоо руу орж санамсаргүйгээр оролцуулахыг чухалчилсан. Мөн суурин болон хөдөө нутгийн төлөөллийг оруулахын тулд сумын төвөөс гарч мал маллаж буй өрх айлуудаар явж, эрүүл мэндийн төвийн эмч ажилчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчид, сургуулийн багш, аж ахуйн ажилтан гээд олон хүмүүсийг хамруулсан нь тухайн сумын төлөөлөл нэмэгдэж байна.



Диagramм 1. Судалгаанд оролцогчдын хүйсийн харьцаа



Диаграмм 2. Судалгаанд оролцогчдын насны бүлэг

Айлд орж судалгаа авахдаа судалгааны зорилго, цуглуулсан мэдээллийг хэрхэн ашиглах, хүмүүсийн нэрийг нууцлах талаар тодорхой тайлбарлаж зөвшөөрөл авах нь маш чухал хэсэг байсан. Харин төгсгөлд нь биднийг Баяндун сумаас явах хүртэл энэхүү судалгааны тоглоом, асуулгын талаар бусдад дамжуулахгүй байх тухай анхааруулж, судалгааны нууцлалыг хангахын төлөө тал талаасаа хичээн ажилласан.

Оролцогч бүрийн цаг завьг харгалзан үзэж, тэдний судалгаа өгөх боломж, ажлын нөхцөлийг харж, зарим үед эмнэлгийн ажилчидтай ажлынх нь завсарлагаагаар авч, дундуур нь өвчтөн ирвэл үйлчилгээ үзүүлж дуустал нь хүлээж, заримыг нь оройн цагаар, заримыг нь бид өөрсдийн байрлаж буй газраа дуудан судалгаагаа авсан. Ингэснээр зөвхөн оролцогчийн тоог гүйцээх гэж яарахаас илүү тэдний оролцооны чанарыг чухалчилж судалгааны явцад учирч болох саад бэрхшээлийг даван туулах үе цөөнгүй тохиолдсон. Ийнхүү олон төрлийн амьдралын хэв маягтай, бүх насны бүлгийг хамруулж төлөөлөх чадварыг хангаснаар судалгааны үр дүн баталгаатай, бодитой гарахад дөхөм болсон юм.

### **Мэдээлэл боловсруулах, дүн шинжилгээ хийхэд гарч буй дутагдал**

Манай судалгааны үндсэн хэлбэр нь тоон мэдээлэл цуглуулах зорилготой боловч ажиллах явцдаа дан ганц тоон өгөгдлөөр тухайн нутгийнхны үзэл бодол, итгэл үнэмшлийг бүрэн тайлбарлахад хангалтгүй. Иймээс цаг гарвал чанарын судалгааны аргыг хослуульж тэдний амьдралын хэвшил, итгэл үнэмшил, иргэдийн аж байдлын талаар дэлгэрүүлэн асууж, яриа өрнүүлэхээ мартаагүй юм. Зарим үед ахмад настнууд, олон жил мал малласан хүмүүс, сумын төвд жимс ногоо олон жил тариалсан хөдөлмөрч иргэдтэй ярилцах цагийг тусгайлан гаргахыг хичээдэг байв.

Судалгаа хийх явцад бидний хамгийн эхэнд тулгарсан бэрхшээл бол олон улсад хэрэгжиж байгаа төслийн асуултыг монголчлох явдал байв. Жишээлбэл “та бурхны тухай хэр их боддог вэ?”, “та хэр олон удаа бурханд залбирдаг вэ?” гэх мэт асуултуудыг хүмүүс хооронд нь ялгаж ойлгоход тун хүндрэлтэй байлаа. Монголчуудын хувьд бурхан багшаа зориуд бодох, санаатай залбирах хэмээх ойлголт байхгүй, харин өдөр тутмын амьдралын зуршил, дадал нь суучихсан байдаг. Өөрөөр хэлбэл шашны талаарх үйл явдлуудыг тусгайлан бодож хийдэг бус амьдралынх нь хэвшил болсон тул тэр тухайгаа хэл яриагаар илэрхийлэх болон “өдөр бүр” “долоо хоног бүр”, “сард нэг удаа”, “жилд нэг удаа гэсэн хариултаас сонгох хэцүү байгаа нь ажиглагдсан.

Асуулгын дараагийн хэсэгт уул усны эзэн, лус савдаг ба бурхан хоёрыг ялгаж асуух шаардлага гарсан. Бидний зорилго бол бурхны шашны ойлголт болон уул усны эздийн тухай ойлголтын ялгааг тодруулах байсан. Гэвч нутгийн иргэдийн хувьд энэ хоёрын талаар бараг нэгэн цул мэт ойлгодог. Сайн сайхан байхыг даатгана, муу зүйлээс хамгаалахыг хүснэ. Иймээс хүмүүс “бурхан ингэдэг, уул усны эзэн тэгдэг” гэж ялгаж хэлэх нь бараг боломжгүй байв. Ийнхүү бид бурхан болон уул усны эзэд гэдгийг судалгаан дээр ялгаатайгаар үзэж байгаа тул тэдэнд мөн ялгаатайгаар ойлгуулахын тулд олон жишээ хэлж тайлбарлах, төсөөлүүлж бодоход нь туслах шаардлагатай болсон. Харин энэ явдал удаан үргэлжлэх үед зарим хүн залхаж, “энэ чинь адилхан шүү дээ” гэж төвөгшөөх тохиолдол гарч байв.

Түүнчлэн хүн амын асуулга дээрх “сайн” ба “муу”-гийн тухай ойлголтыг тодорхойлж хариулах хэсэгт бас нэг сонирхолтой зүйл ажиглагдсан. Ахмад настнууд сайн хүний 5 шинж, муу хүний 5 шинжийг огтхон ч эргэлзэхгүй, шууд хариулж байсан бол залуучууд, дунд насныхан энэ тухай удаан бодож, зарим нь “мэдэхгүй” гэж хэлдэг байлаа. Энэ нь үе хоорондын үнэт зүйн ялгаа хэрхэн холдож байгаагийн илрэл мэт.

Судалгааны хамгийн эмзэг хэсэг нь судлаач болон оролцогчийн хооронд үүсэж болзошгүй үл ойлголцлыг багасгах асуудал байлаа. Ялангуяа бидний ашигласан туршилтын тоглоомууд нь шууд мөнгө, урамшууллын хуваарилалттай холбоотой байсан учраас оролцогчид судлаачид таалагдахаар тоглох, эсвэл бодит зан төлөвөөсөө өөрөөр хариу өгөх магадлал өндөр байсан. Үүнээс сэргийлэхийн тулд бид аль болох төвийг сахисан, дарамт үүсгэхгүй, тоглогч ямар нэг зүйл урьдчилан таах, бодох оролдлогыг багасгах орчныг бүрдүүлэхийг хичээсэн. Ингэхдээ оролцогчдын тоглоомын явцад хожсон зоос, хуваарилагдсан мөнгийг дэргэд нь тоолж бичихээс зайлсхийж тоолох үедээ гадаа гарч, тусдаа бичдэг байв. Энэ үед судлаач олон зүйлд анхаарал хандуулснаас болж ямар нэг хэсгийг мартаж, тоолсон зоосоо солих гэх мэт зохион байгуулалтын хувьд нэмэлт хүндрэл дагуулсан. Ийм нөхцөлд тоглоомын үр дүнг зөв бүртгэх, алдаагүй тооцоолохын

тулд зөвхөн энэ ажлыг хариуцах хүн хэрэгтэй байсан. Гэвч бидний багийн хүрэлцээ, хүн хүчний боломж хангалтгүй байсан тул нэг хүн олон үүрэг давхар гүйцэтгэх, заримдаа хугацаа алддаг байлаа.

### Туршилт, тоглоом судалгааны үр дүн

Өмнөх ижил төрлийн судалгаанууд ихэвчлэн оролцон ажиглалт, ярилцлагын аргаар хийгдэж ирсэн бол энэхүү судалгаа нь туршилт тоглоомын арга, асуулгыг хавсран ашигласнаараа онцлог юм. Ингэснээр хүмүүсийн бодит үйлдэл болон тоон мэдээлэлд тулгуурласан илүү найдвартай үр дүн гарсан болов уу? хэмээн таамаглаж, төслийн удирдагчид эдгээр тоон мэдээлэлд үндэслэн цаашид ямар дүгнэлт хийх нь сонирхолтой.

Бидний хувьд дөрвөн төрлийн тоглоомын үр дүнг харьцуулан авч үзэх бөгөөд Баяндун, Дуут, Өөртөө, Дуут гэсэн аяга болон дугтуйнд хуваарилагдсан мөнгөний хэмжээ бараг тэнцүү хэмээн дүгнэж болохоор байна. Тухайлбал аягатай тоглоомын үед “Баяндунд” нийт 1273 зоос, “Дуутад” 1217 зоос бүртгэгдсэн бол аяганы нэр солигдоход “Өөртөө” 1275 зоос, “Дуутад” 1215 зоос ноогджээ.

Харин дугтуйнд мөнгө хуваарилах тоглоомын үр дүн илүү сонирхолтой дүр зураг харуулжээ. “Баяндун-Дуут” гэсэн тойрогт Баяндун 439, Дуут 391 “мянган төгрөг” хуваарилсан бол “Өөртөө-Дуут” гэсэн хувилбарт оролцогчид Өөртөө 399, Дуутад 431 “мянган төгрөг” хуваарилсан байна. Туршилтад ашигласан нэг зоосыг 1000 төгрөгөөр үнэлсэн бөгөөд дугтуйнд мөнгө хуваарилах тоглоомын үед нэг тойрогт хоёр дугтуй өгч 10,000 төгрөгийг өөрийн хүссэнээр хуваан хийх ба энэ тойрог хоёр удаа явагдсан тул оролцогч бүр нийт 20,000 төгрөгийг дугтуйнд хуваарилсан. Иймээс дээр дурдсан 1273 хэмээх тоо нь бодит мөнгөн дүнгээр илэрхийлбэл 1,273,000 төгрөгийг илтгэж байгаа юм. Ийнхүү Баяндунд ирсэн 1,273,000 төгрөгийг санамсаргүй байдлаар нутгийн иргэдэд тарааж өгсөн билээ.

| Шоо орхиж зоос хуваарилах тоглоом |      |        |      |
|-----------------------------------|------|--------|------|
| Баяндун                           | Дуут | Өөртөө | Дуут |
| 1273                              | 1217 | 1275   | 1215 |

Хүснэгт 1. Нэгдүгээр тоглоомын үед ноогдсон мөнгөн дүн

| Дугтуйд мөнгө хуваарилах тоглоом |      |        |      |
|----------------------------------|------|--------|------|
| Баяндун                          | Дуут | Өөртөө | Дуут |
| 439                              | 391  | 399    | 431  |

Хүснэгт 2. Хоёрдугаар тоглоомын үед ноогдсон мөнгөн дүн

Ийнхүү эдгээр тоглоом, 60 гаруй асуулт бүхий асуулга, задгай хариулт зэргээс гадна энэ судалгаа явуулснаас нэг жилийн дараа буюу 2025 онд Баяндун сумд энэ сэдвийн дагуу чанарын судалгаа явуулахаар дахин ирсэн билээ. Ингэхдээ тэдний дунд ерөнхий бурхан хэмээх ойлголт болон уул усны эзэн, лус савдаг зэргийг илүү лавшруулжээ. Ингэснээр Шашин нь хүмүүсийн үйлдлийг хянах, ёс суртахууны хэм хэмжээг тогтоох замаар хамтын ажиллагаа, бусдыг бодох хандлага зэрэг нийгмийн механизм болж ажилладаг эсэхийг тодруулах гэсэн үндсэн зорилгоо биелүүлэх ажээ.

Тоглоом туршилтын арга нь сонирхолтой боловч хэт олон асуулга, тэр дундаа адилхан зүйлсийн талаар асуух нь оролцогчдыг ядрааж, таамгаар хариулах эрсдэлд хүргэх магадлалтай. Иймээс асуулгыг цөөлж, ойлгомжтой, гол үзүүлэлтэд анхаарах нь илүү чухал. Туршил хийхдээ хэт төвөгтэй дүрэм бүхий тоглоом бус оролцогч шууд ойлгоод тоглож чадах энгийн загвар ашиглавал үр дүнтэй хэмээн дүгнэсэн юм.

### **Дүгнэлт**

Энэхүү судалгаа нь бэлчээрийн мал аж ахуй эрхэлдэг буриад угсаатны бүлгийн дунд шашин шүтлэг, уул усны эздийн талаарх итгэл үнэмшил нь хамтын ажиллагаанд хэрхэн нөлөөлж байгааг туршилт-тоглоомын аргаар тодорхойлохыг зорьсон билээ. Бидний хэрэгжүүлсэн энэхүү арга зүй нь оролцогчдын шийдвэр гаргах үйл явц болон бодит зан үйлийг мөнгөн урамшуулал ашиглан хэмжих боломж олгосноороо онцлог юм. Ийнхүү чанарын болон тоон аргыг хослуулсан нь ярилцлагаар илрүүлэх боломжгүй хүний өгөөмөр зан, итгэлцэл, хамтын ажиллагааны нарийн хэмжүүрүүдийг бодитой, хэмжигдэхүйц өгөгдөл болгон баримтжуулж өглөө.

Туршилтын явцад Дорнод аймгийн Баяндун сумын иргэд өөрсөдтэйгөө угсаа гарал, шашин шүтлэгийн ижилсэл бүхий Ховд аймгийн Дуут сумын иргэдэд мөнгө хуваарилсан бөгөөд үр дүнд нь хоёр суманд оногдсон мөнгөн дүн бараг тэнцүү гарсан байна. Энэ нь оролцогчид алслагдсан бүлгийн гишүүндээ өөрийн нэгэн адил өгөөмөр хандаж буйг харуулж байгаа юм. Үүгээрээ шашин шүтлэг болон угсаа гарвал нэгтэй байх нь хүмүүсийн дунд гүн итгэлцлийг бий болгож, газар нутгийн байрлалаас үл хамааран харилцан туслах (reciprocity) хүчтэй хөшүүрэг болдгийг баталж байна. Оролцогчдын гаргасан энэхүү зан үйл нь хувь хүнийг зөвхөн ашгийн төлөөх рациональ сонголт хийдэг агент гэж үздэг онолын таамаглалыг няцааж, эдийн засгийн шийдвэр нь орон нутгийн бүлгийн харилцаа, соёлын үнэт зүйлд гүн шингэсэн байдгийг тод харууллаа. Тоон болон чанарын өгөгдлийг ийнхүү нэгтгэн тайлбарласан нь хүмүүс хоорондын харилцааны нарийн төвөгтэй байдлыг судлахад арга зүйн шинэлэг давуу тал авчирч байна. Цаашид Дуут сумын судалгааны үр

дүнг харьцуулсан болон төслийн ерөнхий багийн нэгдсэн дүгнэлт гарахад илүү сонирхолтой, гүнзгийрүүлсэн үр дүн танилцуулагдана хэмээн хүлээж байна.

### Талархал

Тус өгүүллийн хээрийн судалгаа хийхэд дэмжлэг үзүүлсэн Аархусын их сургуулийн “Бурхад, Тоглоом, Нийгэм-экологийн орчин” (TRT-2022-31107) судалгааны төсөлд болон мэдлэг туршлагаасаа харамгүй хуваалцсан Дорнод аймгийн Баяндун сумын иргэдэд талархал илэрхийлье. Түүнчлэн бидэнд судалгаанд оролцох боломж олгож, арвин их зөвлөгөө өгч, цаашдын судалгаанд үнэтэй хувь нэмэр оруулсан төслийн удирдагч И. Бямбабаатар (Ph.D) багшдаа гүн талархал илэрхийлж байна.

### Ном зүй

- Bliege Bird, Rebecca, Eric Smith, and Douglas W. Bird. 2001. “The Hunting Handicap: Costly Signaling in Human Foraging Strategies.” *Behavioral Ecology and Sociobiology* 50 (1): 9–19.
- Bold, B. 1996. “Socio-Economic Segmentation: Khot-Ail in Nomadic Livestock Keeping in Mongolia.” *Nomadic Peoples* 39: 69–86.
- Camerer, Colin. 2003. *Behavioral Game Theory: Experiments in Strategic Interaction*. Princeton, NJ: Princeton University Press.
- Conte, Thomas J. 2022. “Steppe Generosity: Kinship, Social Reputations, and Perceived Need Drive Generous Giving in a Non-Anonymous Allocation Game among Mongolian Pastoral Nomads.” *Evolution and Human Behavior* 43 (2): 141–151. <https://doi.org/10.1016/j.evolhumbehav.2022.01.001>.
- Cronk, Lee. 2007. “The Influence of Cultural Framing on Play in the Trust Game: A Maasai Example.” *Evolution and Human Behavior* 28 (5): 352–358.
- Cronk, Lee, and Athena Aktipis. 2018. “Design Principles for Risk-Pooling Systems.” *Nature Human Behaviour* 2: 756–762.
- Firth, Raymond. 1967. *Themes in Economic Anthropology*. London: Tavistock.
- Gerkey, David. 2013. “Cooperation in Context: Public Goods Games and Post-Soviet Collectives in Kamchatka, Russia.” *Current Anthropology* 54 (2): 144–176.
- Giddens, Anthony. 1979. *Central Problems in Social Theory: Action, Structure and Contradiction in Social Analysis*. Berkeley: University of California Press.
- Gurven, Michael. 2004. “Economic Games among the Amazonian Tsimane: Exploring the Roles of Market Access, Costs of Giving, and Cooperation on Pro-Social Game Behavior.” *Experimental Economics* 7 (1): 5–24.

- Hamilton, W. D. 1964. "The Genetical Evolution of Social Behavior I & II." *Journal of Theoretical Biology* 7 (1): 1–52.
- Henrich, Joseph, Robert Boyd, Samuel Bowles, Colin Camerer, Ernst Fehr, Herbert Gintis, and David Tracer. 2005. "'Economic Man' in Cross-Cultural Perspective: Behavioral Experiments in 15 Small-Scale Societies." *Behavioral and Brain Sciences* 28 (6): 795–815.
- Henrich, Joseph, Jean Ensminger, Robert McElreath, et al. 2010. "Markets, Religion, Community Size, and the Evolution of Fairness and Punishment." *Science* 327 (5972): 1480–1484.
- Hill, Kim R., Brian M. Wood, Jacopo Baggio, A. Magdalena Hurtado, and Robert Boyd. 2014. "Hunter-Gatherer Inter-Band Interaction Rates: Implications for Cumulative Culture." *PLoS ONE* 9 (7): e102806.
- Humphrey, Caroline, and David Sneath. 1999. *The End of Nomadism? Society, State, and the Environment in Inner Asia*. Durham, NC: Duke University Press.
- Lightner, Adam D., Tobias Bendixen, and Benjamin G. Purzycki. 2023. "Moralistic Supernatural Punishment Is Probably Not Associated with Social Complexity." *Evolution and Human Behavior* 44 (6): 555–565.
- Marlowe, Frank. 2004. "Dictators and Ultimatums in an Egalitarian Society of Hunter-Gatherers: The Hadza of Tanzania." In *Foundations of Human Sociality*, edited by Joseph Henrich, Robert Boyd, Samuel Bowles, et al., 168–193. Oxford: Oxford University Press.
- Mook, L. 1986. "Economic Anthropology and the Substantivist-Formalist Debate: A Review." *Canadian Review of Sociology/Revue canadienne de sociologie* 23 (1): 47–66.
- Purzycki, Benjamin G., et al. 2016. "Moralistic Gods, Supernatural Punishment and the Expansion of Human Sociality." *Nature* 530: 327–330.
- Sahlins, Marshall. 1972. *Stone Age Economics*. Chicago: Aldine.
- Turner, Billie L., and Stephen B. Brush. 1987. *Comparative Farming Systems*. Gainesville: University Press of Florida.

